



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/031/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026.02.25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn
Аудитор: А.Адилзаяа
Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ИХ БОГДЫН
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Г.НАНСАЛМАА ТАНАА

2026.02.16 № 2/22
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тус байгууллага нь 2025 онд эрх бүхий байгууллагын шийдвэрээр 346,399.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, балансын үнийг нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050104

Тайлант онд улсын төсвөөс батлагдсан хуваарийн дагуу санхүүжилт олгоогүйгээс 5,465.0 мянган төгрөгийн байгууллагад төлөх өр төлбөр үүссэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд нийт 22 ажил төлөвлөснөөс хэрэгжилт 96 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	99,698,134.00	77,586,810.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,858,298.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,858,298.00	00.00
3121	Төгрөг	22,858,298.00	00.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	22,858,298.00	00.00
33	АВЛАГА	00.00	17,410,698.00
335	Бусад авлага	00.00	17,410,698.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	17,410,698.00
35	БАРАА МАТЕРИАЛ	76,839,836.00	60,176,112.41
351	Түүхий эд материал	73,530,236.00	58,013,684.41
35110	Тусгай зориулалттай материал	73,530,236.00	58,013,684.41
354	Хангамжийн материал	3,309,600.00	2,162,428.00
35420	Аж ахуйн материал	3,309,600.00	2,157,700.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	4,728.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	238,872,769.31	477,491,134.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	238,872,769.31	477,491,134.88
392	Биет хөрөнгө	237,204,835.98	465,499,688.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,870,117.88	12,870,117.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,305,518.04	-1,939,771.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	266,153,073.78	554,482,408.95
39204	Хуримтлагдсан элэгдэл	-132,737,953.80	-182,550,361.61
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	108,915,078.66	127,908,025.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,096,609.85	-49,556,865.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,665,600.00	10,665,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,258,952.65	-6,379,466.56
393	Биет бус хөрөнгө	1,667,933.33	11,991,446.69
39301	Програм хангамж	1,267,933.33	1,267,933.33
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-253,586.64
39303	Бусад биет бус хөрөнгө	400,000.00	10,977,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	338,570,903.31	555,077,945.29
413	Өглөг	00.00	5,465,013.00
4136	Бусад өглөг	00.00	5,465,013.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	5,465,013.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	338,570,903.31	549,612,932.29
51	Засгийн газрын хувь оролцоо	338,570,903.31	549,612,932.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	36,953,494.00	36,953,494.00
512	Хуримтлагдсан үр дүн	300,497,291.19	511,539,320.17
51210	Өмнөх үеийн үр дүн	300,497,291.19	300,497,291.19
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	211,042,028.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,120,118.12	1,120,118.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	338,570,903.31	555,077,945.29

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,081,337,718.53	1,185,808,144.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	168,293,910.03	360,294,362.10
120	Нийтлэг татварын бус орлого	168,293,910.03	360,294,362.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	168,293,910.03	360,294,362.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	7,655,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	913,043,808.50	825,513,782.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	861,825,344.50	813,821,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	851,633,100.00	813,821,300.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	10,192,244.50	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,323,464.00	11,692,482.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	6,692,482.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,049,000.00	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	274,464.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,895,000.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,895,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	973,961,380.42	974,766,115.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	973,961,380.42	974,766,115.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	850,561,184.92	924,867,627.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	593,791,781.72	681,055,663.20
210101	Үндсэн цалин	326,833,370.87	353,138,300.00
210102	Нэмэгдэл	133,447,010.85	206,214,829.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	87,630,000.00	81,272,400.00
210104	Урамшуулал	45,881,400.00	40,430,133.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,347,094.28	83,078,531.76
210201	Тэтгэврийн даатгал	48,792,410.11	57,287,542.55
210202	Тэтгэмжийн даатгал	5,699,141.23	6,739,710.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,849,570.45	3,369,855.41
210204	Ажилгүйдлийн даатгал	2,601,194.70	3,136,284.58
210205	Эрүүл мэндийн даатгал	10,404,777.79	12,545,138.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,700,000.00	00.00
210304	Байрны түрээс	2,700,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,839,560.00	8,981,395.00
210401	Бичиг хэрэг	3,259,300.00	1,463,300.00
210402	Тээвэр, шатахуун	21,262,660.00	3,435,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,292,800.00	2,187,355.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	537,500.00

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,024,800.00	1,358,000.00
2105	Нормативт зардал	12,438,350.00	14,508,154.52
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,438,350.00	14,508,154.52
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,646,000.00	7,443,900.00
210604	Урсгал засвар	23,646,000.00	7,443,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,052,000.00	1,790,000.00
210702	Дотоод албан томилолт	5,052,000.00	1,790,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,389,982.00	38,181,675.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,148,879.00	36,376,520.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	50,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	67,335.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	264,000.00	612,687.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	93,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	358,500.00
210807	Газрын төлбөр	137,768.00	417,768.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	72,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,356,416.92	89,828,307.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	880,170.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,226,246.92	89,828,307.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,400,195.50	49,898,488.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,448,400.08	8,950,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	28,731,000.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,453,400.08	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,264,000.00	8,950,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,951,795.42	40,948,488.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,951,795.42	40,948,488.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	107,376,338.11	211,042,028.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	914,043,808.50	833,168,782.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,000.00	7,655,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	7,655,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	7,655,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	7,655,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	913,043,808.50	825,513,782.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	861,825,344.50	813,821,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	851,633,100.00	813,821,300.00

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	313,252.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	358,500.00
210807	Газрын төлбөр	137,768.00	381,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	72,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,170.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	880,170.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	320,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,400,195.42	49,748,488.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,448,400.00	8,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,600,000.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,453,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,395,000.00	8,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,951,795.42	40,948,488.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,951,795.42	40,948,488.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28,575,000.00	-22,858,298.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,900,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,900,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,900,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,900,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-11,900,000.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	16,675,000.00	-22,858,298.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,183,298.00	22,858,298.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,858,298.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	48,137,560.65	00.00	86,211,172.77
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	48,137,560.65	00.00	86,211,172.77
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	17,229,463.91	00.00	17,229,463.91
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	300,497,291.19	00.00	338,570,903.31
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	300,497,291.19	00.00	338,570,903.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	300,497,291.19	00.00	338,570,903.31
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	211,042,028.98	00.00	211,042,028.98
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	511,539,320.17	00.00	549,612,932.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	821,746,100.00	821,476,300.00	269,800.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	820,246,100.00	813,821,300.00	6,424,800.00	99.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	820,246,100.00	813,821,300.00	6,424,800.00	99.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.00	7,655,000.00	-6,155,000.00	510.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	7,655,000.00	-6,155,000.00	510.3
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	821,746,100.00	791,783,509.46	29,962,590.54	96.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	821,746,100.00	791,783,509.46	29,962,590.54	96.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	821,746,100.00	791,783,509.46	29,962,590.54	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	693,000,700.00	674,363,180.70	18,637,519.30	97.3
210101	Үндсэн цалин	353,138,300.00	353,138,300.00	0.00	100.0
210102	Нэмэгдэл	200,181,300.00	199,522,347.28	658,952.72	99.7
210104	Урамшуулал	58,408,700.00	40,430,133.42	17,978,566.58	69.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,978,000.00	83,078,531.76	4,899,468.24	94.4
210201	Тэтгэврийн даатгал	59,851,900.00	57,287,542.55	2,564,357.45	95.7
210202	Тэтгэмжийн даатгал	7,041,400.00	6,739,710.89	301,689.11	95.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,520,700.00	3,369,855.41	150,844.59	95.7
210204	Ажилгүйдлийн даатгал	3,512,800.00	3,136,284.58	376,515.42	89.3
210205	Эрүүл мэндийн даатгал	14,051,200.00	12,545,138.33	1,506,061.67	89.3
2104	Хангамж, бараа материалын зардал	9,341,500.00	8,342,300.00	999,200.00	89.3
210401	Бичиг хэрэг	2,416,800.00	1,665,300.00	751,500.00	68.9
210402	Тээвэр, шатахуун	2,928,200.00	2,928,200.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,101,000.00	1,853,300.00	247,700.00	88.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	537,500.00	537,500.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,358,000.00	1,358,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,643,900.00	6,643,900.00	0.00	100.0

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	6,643,900.00	6,643,900.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,790,000.00	1,790,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	1,790,000.00	1,790,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,992,000.00	17,565,597.00	5,426,403.00	76.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,137,400.00	16,137,200.00	200.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,508,500.00	3,600.00	2,504,900.00	0.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	343,600.00	299,045.00	44,555.00	87.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	314,800.00	313,252.00	1,548.00	99.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	358,500.00	358,500.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	381,400.00	381,400.00	0.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,813,400.00	72,600.00	2,740,800.00	2.6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	23	2	92.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22	20	2	90.9
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0	100.0

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,692,482.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,692,482.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,692,482.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,692,482.50
210102	Нэмэгдэл	6,692,482.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11692482.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,692,482.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,692,482.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц, тогтоц ховор, ховордсон ургамал, амьтан бүхий сав газар, түүх соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, харьяалагдах газар нутгийнхаа биологийн төрөл зүйл, байгалийн нөөц ашиглалт, хяналт хамгаалалтыг сайжруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн эко аялал, жуулчлалыг дэмжих зорилго тавьж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хэрэгжүүлдэг ба тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 216,507.0 мянган төгрөгөөр буюу 1.6 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,858.30	-	-22,858.30
Авлага	-	17,410.70	17,410.70
Бараа материал	76,839.84	60,176.11	-16,663.72
Үндсэн хөрөнгө	238,872.77	477,491.13	238,618.37
Хуримтлагдсан элэгдэл	(161,399.03)	(240,680.05)	-79,281.02
Нийт хөрөнгө	338,570.90	555,077.95	216,507.04
Өглөг	-	5,465.01	5,465.01
Засгийн газрын хувь оролцоо	338,570.90	549,612.93	211,042.03
Тайлант үеийн үр дүн	-	211,042.03	211,042.03
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,120.12	1,120.12	0.00
Нийт өр төлбөр цэвэр хөрөнгө/өмчийн дүн	338,570.90	555,077.95	216,507.04

Тус байгууллага мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Тайлант онд байгууллагын ахмадын сангийн эхний үлдэгдэл 22,858.3 мянган төгрөгөөс Ахмадын сан байгуулан ажиллах журмын 3 дугаар зүйл 3.1 дэх заалтын хүрээнд байгууллагын даргын 2025 оны А/07, А/24, А/29, А/36 дугаар тушаалаар нийт 11,602.6 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 11,255.7 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь БОАЖС-ын 2023 оны А/437 дугаар тушаалыг үндэслэн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар байгууллагын бүтцийг 24 орон тоотойгоор баталж, үйл ажиллагаа явуулсан бөгөөд БОУАӨС-ын 2025 оны А/688 дугаар тушаалыг үндэслэн байгууллагын даргын 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар 9 хувиар буюу 2 орон тоогоор бууруулан, 2025 онд 22 орон тоотой ажиллахаар шинэчлэн баталсан байна.

2025 онд байгууллагын хоол, унааны хөнгөлөлтөд улсын төсвөөс 81,272.4 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 81,272.4 мянган төгрөг зарцуулсан байна. Тус хөнгөлөлтийг байгууллагын дотоод журмын 5.2 дахь заалтыг үндэслэн байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар өдрийн 20.0 мянган төгрөгөөр тогтоожээ.

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 820,248.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 1,500.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 813,821.3 мянган төгрөг, өөрийн орлогоор 7,655.0 мянган төгрөг төвлөрүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 791,783.5 мянган төгрөгийг зарцуулж, 29,692.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Авлагын дансны үлдэгдэл 17,410.7 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын ахмадын сангийн дансны үлдэгдэл 11,255.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 6,255.0 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 60,176.1 мянган төгрөг болж оны эхний үлдэгдлээс 16,663.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд зарцуулсан тусгай зориулалтын материал 44,805.7 мянган төгрөгийн зардал голлох нөлөөг үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 477,491.1 мянган төгрөг болж оны эхний үлдэгдэл хөрөнгөөс 238,618.4 мянган төгрөгөөр өссөн нь БОУАӨС-ын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/325 дугаар тушаал, БОУАӨС-ын 2025 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн А/729 дүгээр тушаал, БОУАӨЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/364 дүгээр тушаалаар үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 346,399.4 мянган төгрөгийн газар, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, ТӨБЗГ-ын 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 437 дугаар тогтоолоор байгууллагад бүртгэлтэй 28,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлсэн нь нөлөөлжээ.

Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй 1,267.9 мянган төгрөгийн өртөг бүхий Санхүүгийн тооцоолох группийн "Acolous" программыг урсгал зардлын төсвөөс 325.5 мянган төгрөгөөр ашиглах эрх худалдан авч, өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тайлант онд өглөгийн дансны үлдэгдэл 5,465.0 мянган төгрөг болж нэмэгдсэн нь 12 дугаар сард төсвийн тодотгол хийж зардлын дүнг бууруулж, гүйлгээг хязгаарласнаас байгууллагад төлөх өглөг үүссэн байна. Дээрх өглөгийг дараагийн аудитаар анхаарах хэсэгт оруулсан болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,231,041.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 1,500.0 мянган төгрөгөөр, урсгал зардлын дүнг 1,232,541.3 мянган төгрөгөөр тооцож дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 791,783.5 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 96.4 хувийг зарцуулсан байгаа нь тайлант онд албан хаагчдад олгох

урамшууллын зардал 30.8 хувиар хэмнэгдэж, оны эцэст гүйлгээ хязгаарласантай холбоотойгоор зарим зардлыг төлөөгүй, өглөг үүссэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71405 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт					
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	805,608.70	805,338.90	269.80	99.97
2	81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	11,999.30	11,999.30	-	100.00
3	81703 Ургамал хамгаалал	4,138.10	4,138.10	-	100.00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд албан хаагчдын орон нутаг ажилласны нэмэгдэл 6,692.5 мянган төгрөг, Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн захирамжаар бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний урамшуулал 5,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн

аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны 3 дугаар улирлын байдлаарх нийт санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны 3 дугаар улирлын байдлаарх нийт санхүүжилтийн дүн болох 813,821.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,138.2 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 5,289.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад 2025 оны батлагдсан төсөв 821,746.1 мянган төгрөгөөс тооцон 5,341.4 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн оруулсан бөгөөд үндсэн мэдээлэл хэсэгт

байгууллагын дарга, нягтлан бодогчийн мэдээллийг шинэчлэн оруулаагүй байсныг аудит явцад залруулж, мэдээлсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын байгууллагын аудитор Ц.Дорж гүйцэтгэсэн бөгөөд аудитаар 339.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, тайлант хугацаанд бүрэн биелсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	339.0	1	339.0	100
Нийт дүн	1	339.0	1	339.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант оны 12 дугаар сард төсвийн тодотголоор санхүүжилт буурч, төсвийн хуваарийн дагуу санхүүжилт олгоогүйн улмаас 5,465.0 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг үүссэн байна. Цаашид төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн хуваарилалт, өр төлбөрийн удирдлагад эрсдэл үүсэх магадлалтай тул өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажилласан байдал, төсвийн тодотгол хийх үеийн өр төлбөрийн тооцоонд анхаарч, дараагийн аудитаар давтагдсан эсэхийг үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2 зөрчил^(ОВ) илэрсэнд 1 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг зөрчил илрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

5.1.1 Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 7 тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хамрагдах хугацаа дууссан байхад техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамрагдаагүй байна.

Энэ нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх "Тээврийн хэрэгслийг эзэмшигч Монгол Улсад бүртгэлтэй механикжсан тээврийн хэрэгслийг ашиглалтын явцад тогтоосон хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамруулах үүрэгтэй" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 12 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх ,

цаашид тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоонд шаардлагатай төсвийг оновчтой бодит хэрэгцээнд тулгуурлан оновчтой төлөвлөж байх зөвлөмж хүргүүлэв.

5.2 Албан шаардлага

5.2.1 Байгууллагын эзэмших эрхийг гэрчилгээтэй 10,000.0 м.кв хэмжээтэй, 6409013284 нэгж талбарын дугаар бүхий газрыг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйл 14.4 дэхь "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийн заавал бүртгэнэ", 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", УСОУНББ 17 Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: 2026 оны хагас жилийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийг тусган, зөрчлийг арилгах, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 06-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 7 тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хамрагдах хугацаа дууссан байхад техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамрагдаагүй байна.	1	-					1	-
Байгууллагын эзэмших эрхийг гэрчилгээтэй 10,000.0 м.кв хэмжээтэй, 6409013284 нэгж талбарын дугаар бүхий газрыг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгээгүй байна.	1	-			1	-		
Дүн	2	-			1	-	1	-

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----